



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Тэсийн-Илч ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/14/НА-СТА-ОНА

Цахим хуудас:

www.audit.mn

Хөвсгөл аймаг

2024 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн Аудитын Газрын
Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 88095436 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Аудитыг гүйцэтгэсэн: Си Пи Ти Эй Аудит ХХК-ийн
Захирал: Ч.Энхчимэг
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Аудитор: Б.Бүрэнжаргал
Утас: 77233030 Цахим хаяг: info@cptaaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

НЭГ. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.15 № 01/258

танай _____ -ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН “ТЭСИЙН-ИЛЧ”
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
А.ГАЛБАДРАХ ТАНАА

Хараат бус аудиторын дүгнэлт

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Тэсийн-Илч ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Тэсийн-Илч ХХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Могойн гол” ХК-ийн ТУЗ-ийн 2022 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор Цэцэрлэг сумын Тэсийн илч ХХК-д худалдан авсан нүүрсний нийт үнэнд 80 хувийн хөнгөлөлт үзүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитаар бүртгэл тайлагналтай холбоотой 10.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1 төлбөрийн акт, 2 зөвлөмж хүргүүлж ажиллаа.

Бусад асуудлын хэсэг

Тэсийн-Илч ХХК нь ТУЗ-ийн 2023 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 002 дугаар тогтоолоор 2023 оны бизнес төлөвлөгөөг батлаж, 2023 оны 10 дугаар сарын 04-ны өдрийн 08 дугаар тогтоолоор нийт орлогыг 456.5 сая төгрөгөөр, нийт зардлыг 741.7 сая төгрөгөөр байхаар нэмэлт тодотгол хийснээс 86.3 хувийн орлогын гүйцэтгэлтэй байна.

Хөвсгөл аймгийн ИТХ-аар батлагдсан Эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөөнд суурилж, ТУЗ бизнес төлөвлөгөөгөө шинэчлэн боловсруулж, баталдаг байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6724040634

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	31,088,126.07	1,204,943.76
1.1.2	Дансны авлага	21,190,468.29	62,602,603.12
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	5,523,380.00	-
1.1.6	Бараа материал	27,597,721.64	31,458,194.45
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	85,399,696.00	95,265,741.33
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,317,248,580.68	3,001,772,252.83
1.2.2	Биет бус хөрөнгө	18,922,000.00	18,922,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,336,170,580.68	3,020,694,252.83
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,421,570,276.68	3,115,959,994.16
2.1.1.1	Дансны өглөг	1,000,000.01	41,263,863.93
2.1.1.3	Татварын өр	1,681,425.19	17,621,660.81
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,681,425.19	58,885,524.73
2.2	Өр төлбөрийн нийт дүн	2,681,425.19	58,885,524.73
2.3.1	Өмч: - төрийн	3,632,203,450.00	3,632,203,450.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	256,113,021.51	256,113,021.51
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	633,138,371.06	653,088,371.06
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,102,565,991.08)	(1,484,330,373.14)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	3,418,888,851.49	3,057,074,469.43
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн	3,421,570,276.68	3,115,959,994.16

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	410,279,702.04	393,459,438.00
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	647,277,258.30	709,056,750.49
3	Нийт ашиг (алдагдал)	(236,997,556.26)	(315,597,312.49)
8	Бусад орлого	381,000.00	592,731.74
10	Ерөнхий ба удирдлагын зардал	60,772,322.00	65,156,873.00
11	Санхүүгийн зардал	57,000.00	57,473.77
12	Бусад зардал	-	1,545,454.55
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	284,000.00	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(297,729,878.26)	(381,764,382.06)
19	Орлогын татварын зардал	-	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(297,729,878.26)	(381,764,382.06)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(297,729,878.26)	(381,764,382.06)
24	Орлогын нийт дүн	(297,729,878.26)	(381,764,382.06)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/					
ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2022 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	3,632,203,450.00	252,570,821.51	158,653,522.58	(804,836,112.82)	3,238,591,681.27
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(297,729,878.26)	(297,729,878.26)
Өмчид гарсан өөрчлөлт	-	3,542,200.00	474,484,848.48	-	478,027,048.48
2023 оны 01-р сарын 01- ний үлдэгдэл	3,632,203,450.00	256,113,021.51	633,138,371.06	(1,102,565,991.08)	3,418,888,851.49
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	(381,764,382.06)	(381,764,382.06)
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	19,950,000.00	-	19,950,000.00
2023 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	3,632,203,450.00	256,113,021.51	653,088,371.06	(1,484,330,373.14)	3,057,074,469.43

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	448,241,339.14	433,831,790.54
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	444,909,259.14	432,484,128.80
	Бусад мөнгөн орлого	3,332,080.00	1,347,661.74
1.2	Мөнгөн зарлага (-)	435,981,654.62	460,728,572.85
	Ажиллагчдад төлсөн	163,735,000.31	193,681,293.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	52,840,836.00	56,728,252.77
	Бараа материал худалдан авахад төлсөн	65,784,336.00	38,522,717.44
	Ашиглалтын зардалд төлсөн	39,201,781.10	67,288,339.55
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	54,341,447.78	35,411,683.00
	Татварын байгууллагад төлсөн	45,999,253.43	21,424,244.32
	Бусад мөнгөн зарлага	14,079,000.00	47,380,442.77
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	12,259,684.52	(26,605,182.31)
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	4,475,600.00	3,278,000.00
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,475,600.00	3,278,000.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(4,475,600.00)	(3,278,000.00)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	7,784,084.52	(29,883,182.31)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	23,304,041.55	31,088,126.07
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	31,088,126.07	1,204,943.76

2.5 ТУЗ-аар батлагдсан Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/					
№	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	хэмнэлт хэтрэлт	Хувь
		Жилийн эхнээс	Жилийн эхнээс		
1. Нийт борлуулалтын орлого					
1.1	Халаалтын орлого	368,833,100.00	362,577,000.00	(6,256,100.00)	98.3
1.2	Бохир усны орлого	23,874,100.00	23,255,969.74	(618,130.26)	97.4
1.3	Цэвэр усны орлого	9,892,800.00	7,019,200.00	(2,873,600.00)	71.0
1.4	Хог тээвэр	4,851,000.00	-	(4,851,000.00)	-
1.5	Түрээсийн орлого	3,960,000.00	1,200,000.00	(2,760,000.00)	30.3
1.6	Бусад орлого	19,328,500.00	-	(19,328,500.00)	-
1.7	2023 оны нүүрсний хэмнэлт	25,749,100.00	-	(25,749,100.00)	-
Борлуулалтын орлогын дүн		456,488,600.00	394,052,169.74	(62,436,430.26)	86.3
2. Нийт зардал					
2.1	Нийт цалин хөлс	225,597,700.00	213,683,701.00	(11,913,999.00)	94.7
2.2	Цалингийн НДШ	30,419,700.00	31,000,131.77	580,431.77	101.9
2.3	Нүүрсний зардал	25,749,100.00	21,904,500.00	(3,844,600.00)	85.1
2.4	Нүүрс тээврийн зардал	16,800,000.00	16,800,000.00	-	100.0
2.5	Түлш шатахууны зардал	20,593,800.00	24,540,296.00	3,946,496.00	119.2

2.6	Хог хаягдал зайлуулах зардал	2,500,000.00	2,500,000.00	-	100.0
2.7	бага үнэтэй түргэн элэгдэх зүйл	300,000.00	362,000.00	62,000.00	120.7
2.8	Гэрэл цахилгааны зардал	37,350,000.00	54,253,128.17	16,903,128.17	145.3
2.9	Хөдөлмөр хамгааллын зардал	13,518,000.00	12,782,306.91	(735,693.09)	94.6
2.10	Бичиг хэргийн зардал	3,700,000.00	3,815,100.00	115,100.00	103.1
2.11	Интернэтийн зардал	1,358,800.00	1,115,200.00	(243,600.00)	82.1
2.12	Томилолтын зардал	3,315,800.00	2,748,000.00	(567,800.00)	82.9
2.13	Сэлбэг хэрэгслийн зардал	14,860,000.00	10,532,940.91	(4,327,059.09)	70.9
2.14	Урсгал засвар	16,620,100.00	13,758,979.09	(2,861,120.91)	82.8
2.15	Төлбөр хураамж	7,002,000.00	5,794,900.00	(1,207,100.00)	82.8
2.16	Гамшгаас хамгаалах /БЭЗ/	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
2.17	Сургалт зөвлөгөөний зардал	4,000,000.00	3,278,000.00	(722,000.00)	82.0
2.18	Элэгдлийн зардал	295,859,600.00	334,612,327.85	38,752,727.85	113.1
2.19	ТУЗ-ийн зардал	6,175,100.00	6,275,100.00	100,000.00	101.6
2.20	Хоол хүнсний зардал	4,512,000.00	7,708,435.70	3,196,435.70	170.8
2.21	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	10,450,000.00	7,351,504.40	(3,098,495.60)	70.3
	Нийт зардлын дүн	741,681,700.00	775,816,551.80	34,134,851.80	104.6
	Ашиг алдагдал	(285,193,100.00)	(381,764,382.06)	(96,571,282.06)	133.9

ГУРАВ. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 122.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 21.9 сая төгрөгийн алдааг залруулж, 0.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 100.4 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар залруулагдаагүй зөрчилтэй асуудлын материаллаг бус алдаа зөрчил нь 100.4 сая төгрөг, материаллаг алдаа 0.2 сая тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Могойн гол ХК-с худалдан авсан нүүрсний өглөгийг 21.9 сая төгрөгийг тусган бүртгээгүй байсныг залруулсан.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Ажил эрхлээгүй ажилтныг НДШ-ийн тайланд тайлагнаж, 0.2 сая зардал гаргасан байна. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 19.1.3. “ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого, сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагналыг, урамшуулал” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь : Төлбөрийн акт тогтоох.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой

Илрүүлэлт: Худалдан авалттай холбоотой 10.2 сая төгрөгийн гүйлгээ нь анхан шатны баримттай боловч цахим и-баримтгүй байгаа нь Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13-р зүйлийн 13.1.4; “доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримт, импортын бараанд татвар ногдуулж, гаалийн байгууллагад төлсөн тухай баримтаар баталгаажсан байх” Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.3.1. “Анхан шатны баримт бүрдүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг баталгаажуулж байх

2. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой

Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 9 удаагийн 90.2 сая төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2 “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагыг үнэн зөв мэдээлж байх.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5. Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 04 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмж, төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
							Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дансны өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй	1	21.9			1	21.9	1	21.9		
Дүн	1	21.9			1	21.9	1	21.9		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Ажил эрхлээгүй ажилтныг НДШ-ийн тайланд тайлагнасан	1	0.2	1	0.2				
Худалдан авалттай холбоотой цахим и-баримтгүй гүйлгээ хийсэн	1	10.2					1	10.2
Дүн	2	10.4	1	0.2			1	10.2

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 9 удаагийн мэдээллийг байршуулаагүй.	1	90.2						1	90.2
Нийт дүн	1	90.2						1	90.2

ТАВ. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1				1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1				1			



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 03 сарын 15 өдөр

№ 83/А2270439/МӨА-2024/
14/АА-СМ.А-ОАА

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Тэсийн илч ХХК-ийн 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Компанид 2023 оны 09 дүгээр сард ажил эрхлээгүй иргэн Г.Пүрэвдоржийн нийгмийн даатгалын шимтгэлийг төлж, 179,262.5 /нэг зуун далан есөн мянга хоёр зуун жаран хоёр төгрөг тавин мөнгө/ төгрөгийн зардал гаргасан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т “Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ: хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх;” гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21-р зүйлийн 21.2-т “Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль, тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно” Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Ажил эрхлээгүй Г.Пүрэвдоржийн нийгмийн даатгалын шимтгэлд төлсөн 179,262.5 /нэг зуун далан есөн мянга хоёр зуун жаран хоёр төгрөг тавин мөнгө/ төгрөгийг Г.Пүрэвдоржоор төлүүлж, Хөвсгөл аймгийн Төрийн сангийн 100170000955 /Хө.Бусад нэр заагдаагүй орлого/ тоот дансанд төвлөрүүлэх
2. Актын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар¹т ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын Тэсийн Илч ХХК-ийн захирал А.Галбадрах, нягтлан бодогч Б.Сувд-Эрдэнэ нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

А.ЭРДЭНЭБААТАР

Ч.ЭНХЧИМЭГ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8 дугаар баг, аймгийн ЗДТГ-ын байр, А корпус, 3 давхар, 303 тоот